

2024 оны 07 сарын 16 өдөр

дугаар 49

Улаанбаатар хот

**Ногдол ашиг хуваарилах тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.4, 46.7, 46.8, 46.10, 46.14, 46.15 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг болон “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.16 дахь заалт болон 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

1. Банкны хуримтлагдсан ашгаас нийт хувьцаа эзэмшигчдийн нэгж энгийн хувьцаанд 1,033.00 (Нэг мянга гучин гурав) төгрөгийн ногдол ашиг хуваарилсугай.
2. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг хуваарилах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 7 дугаар сарын 24-ны өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд олгох ажиллагааг банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн хангалттай уялдуулан эрх бүхий зохицуулагч байгууллагаас зөвшөөрлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор багтаан хэрэгжүүлэх, хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлagnaхыг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д үүрэг болгосугай.
4. Ногдол ашиг хуваарилсантай холбоотой тайлан, мэдээг холбогдох журмын дагуу Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлэх болон дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлagnaхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Н.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА